

Аварга дээд сургуулийн оюутны дотуур байранд оршин суух гэрээ

§ 1 Аварга ДС-ийн хүлээх үүрэг, эрх

1. Оюутны байранд суугчийн бүртгэлийг тодорхой гарган зохион байгуулалтын арга хэмжээ авах.
2. Оюутны байрны дотоод журам, ариун цэвэр, эрүүл ахуй, галын аюулгүй байдлын биелэлтэнд хяналт тавьж ажиллах.
3. Гэрээ байгуулагч талууд Аварга ДС-д мөрдөгдөж байгаа хууль эрхийн бичиг баримтуудыг мөрдлөг болгон ажиллана.
4. Оюутны байрны дотоод журам, гэрээний нөхцөлийг удаа дараа зөрчсөн тохиолдолд гэрээг цуцлах эрхтэй.
5. Оршин суугчдыг гэрэл, ус, дулаанаар хангана.
6. Долоо хоногт хуваарийн дагуу халуун усанд оруулна.
7. Байрлагч гэрээний хугацаанд _____ төгрөг төлнө.
8. Байрлагчийн буруутай үйл ажиллагаанаас болж гэрээг цуцалсан бол төлбөрийг буцаан олгохгүй.

§ 2 Оршин суугчийн хүлээх үүрэг

1. Оюутнуудын сурах, амьдрах, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх нөхцөлөөр хангах талаар санал хүсэлтээ тавих эрхтэй.
2. Оюутны байрны дотоод журмыг хатуу мөрдлөг болгож амьдарна.
3. Оюутнууд байрны үнэмлэхээ үүдний жижүүрт шалгуулж орж байх.
4. Байрны эд хогшлыг ариг гамтай эдэлж, эвдрэл гэмтэл гаргах, хананы обой, шалны хулдаасыг гэмтээсэн, үрэгдүүлсэн тохиолдолд хохиролыг бүрэн барагдуулна.
5. Цахилгаан болон хэрэглээний усыг зөв боловсон зарцуулж угаалтуур болон бие засах газрын тоног төхөөрөмжийг гамтай эдлэнэ.
6. Байрандаа архи, тамхи хэрэглэхгүй байх үүнийг зөрчсөн тохиолдолд дотоод журмын дагуу торгуулийн шийтгэл хүлээлгэнэ.
7. Өвлийн цагийн хуваариар 22.00 цаг, зуны цагт 23.00 цагаас хойш зөвшөөрөлгүйгээр байрнаас гарч явах, гаднаас орохыг хориглоно.
8. Гаднаас ямар нэгэн шалтгаанаар хүн оруулж хонуулахыг хатуу хориглоно.
9. Өдрөөр хүн оруулах тохиолдолд байрны багшаас зөвшөөрөл авч жижүүрт шалгуулж орно.
10. Сургуулиас зохиох соёл хүмүүжил болон их цэвэрлэгээний ажилд идэвхитэй оролцоно.
11. Сургуулийн багш, ажилчидтай зөв боловсон харьцана.
12. Байранд тэсрэх дэлбэрэх бодис, согтууруулах ундаа, галт зэвсэг хадгалж хэрэглэхийг хориглоно.

13. Байрнаас түр болон бүр мөсөн гарах тохиолдолд хүлээж авсан эд хогшилоо хүлээлгэж өгнө.

§ 3 Хамтран хүлээх эрх, үүрэг

1. Хоёр тал бие биенээ харилцан хүндэтгэж гэрээг биелүүлэх тааламжтай нөхцөлийг бүрдүүлнэ.
2. Хоёр тал харилцан зөвшилцөж гэрээнд өөрчлөлт оруулж болно.

Гэрээ байгуулсан:

Улаанбаатар хот, 20__ оны __ сарын __ өдөр

Аварга ДС-ийн оюутны байрны
Багш Г. Фрунзе

Оршин суугч: __ ангийн оюутан